



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

200.1 оны 01 дугаар
сарын 08 -ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Дүрэм, орон тоог батлах
тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 3 дугаар заалт, Засгийн газрын 2000 оны 185 дугаар тогтоолын 8 дугаар заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ.

Нэг. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх "Нийтлэг үйлчилгээний газар"-ын дүрмийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Нийтлэг үйлчилгээний газрыг орлогч дарга 1, орон тооны хязгаарыг 93 /үйлчилгээний орлогоос цалинждаг болон нормативаар ажиллах орон тоо ороод/ хүртэл байхаар тогтоосугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын дотоод журмыг шинэчлэн мөрдөх, үйл ажиллагааны стратеги, хэтийн чиглэлийг боловсруулан энэ оны эхний хагас жилд багтаан батлуулах ажлыг зохион байгуулахыг Нийтлэг үйлчилгээний газар /Т.Дашням/-т даалгасугай.

Дөрөв. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1997 оны 6/60 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

60
Нийслэлийн Засаг даргын 8001 оны
13 дугаар захирамжийн хавсралт

НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийтлэг үйлчилгээний газар нь /цаашид "Газар" гэнэ/ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын алба, Засаг даргын дэргэдэх газруудын /цаашид төр, захиргааны байгууллагууд гэнэ/ төсөв, санхүү, үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг хариуцан нийслэлийн Төр захиргааны байгууллагуудад үйлчлэх нийтлэг үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй, санхүү үйлчилгээ, аж ахуйн ажлыг эрхлэн хэрэгжүүлэгч төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоол, шийдвэр, мөрийн хөтөлбөр энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Газар нь Нийслэлийн Засаг дарга, орлогч, Тамгын газрын удирдлаганд үйл ажиллагаагаа явуулж, ажлаа тайлагнана.

1.4. Газрын бүтэц, орон тооны хязгаарыг Нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж чөлөөлнө.

1.5. Газрын дарга нь эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргана.

1.6. Газрын дарга нь нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр орлогч даргаа томилж, чөлөөлнө.

1.7. Газрын дарга нь батлагдсан орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж чөлөөлнө.

1.8. Газар нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.

1.9. Газрын даргын дэргэд байгууллагын зорилт үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэж байх зөвлөлийг ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг газрын дарга батална.

Хоёр. Газрын үүрэг

2.1. Газар нь Монгол улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх.

2.2.Холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамж, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийн явц, үр дүнг хугацаанд нь тайлагнаж ажиллах.

2.3.Нийслэлийн Төрийн захиргааны байгууллагуудад чиглэсэн нийтлэг үйлчилгээний талаархи бодлогыг хэрэгжүүлж, тэдгээрийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах санхүү, аж ахуйн үйлчилгээний ажлыг эрхлэн гүйцэтгэх.

2.4.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газар, Захирагчийн алба холбогдох хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах нөхцөл бололцоог хангах.

2.5.Нийслэлийн төр захиргааны байрууд бусад цэг салбарын дотоод дэг журам, доторх гаднах орчны цавэрлэгээ, тохижилт, засвар үйлчилгээг өндөр түвшинд байлгах.

2.6.Байгууллага, нэгжийн үйл ажиллагааны чиглэл, материал хангамж, дотоод гадаад хамтын ажиллагааг уялдуулах.

2.7.Нийслэлийн гадаад харилцаа хамтын ажиллагааны шугамаар ирсэн зочин, төлөөлөгчдийн ажиллах нөхцөл, байр, хоол зэрэг бүхий л үйлчилгээг хариуцаж зохион байгуулах.

2.8.Нийслэлийн удирдлагын гадаад арга хэмжээний бэлтгэл, үйлчилгээг зохион байгуулж, бэлэг дурсгалын зүйлийн фондын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж байх.

2.9.Үйлчлүүлэгч байгууллагуудын төсөвт зардал, хөрөнгө оруулалт, их болон урсгал засварын зардлыг төлөвлөхөд санал өгөх, төсөвт зардлын зарцуулалтад холбогдох дүгнэлт гаргаж шаардлага тавих.

2.10.Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл тооцооны ажлыг үе шаттайгаар үр өгөөжтэй зохион байгуулж, нэгдсэн тайлан тэнцэл гарган дүн шинжилгээ хийж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2.11.Нийслэлийн төр захиргааны байгууллагыг шаардагдах техник тоног төхөөрөмж, автомашин, эд материалаар хангаж тэдгээрийн тасралтгүй хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж ажиллах.

2.12. Газрын боловсон хүчнийг бэлтгэх, шилж сонгох, давтан сургах, дахин мэргэшүүлэх, мэргэшлийг дээшлүүлэх, хуваарилах ажлыг нийслэлийн төрийн албаны ажилтанг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг дээшлүүлэх бодлоготой уялдуулан зохион байгуулах.

2.13.Үйлчилгээний байгууллагын ажилтнуудын сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон арга хэмжээг хэрэгжүүлэх.

2.14.Эрхэлт байгууллагын ажилтнууд холбогдох зайлшгүй шаардлагатай асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад асуудал боловсруулан оруулж шийдвэрлүүлэх.

2.15. Газрын даргын нийтлэг хэм хэмжээ тогтоосон тушаалыг тухай бүр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст ирүүлж хянуулах.

2.16. Байгууллагын хэмжээнд сахилга дэг журам, төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг сахиулах, ажилтнуудын ажлын цаг ашиглалт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллах.

2.17. Ёслол хүндэтгэлийн чанартай үйл ажиллагаа, түүнд зориулагдсан үйлчилгээг зохион байгуулах ажлыг бүрэн хангах.

Гурав. Газрын эрх

3.1. Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, чиг үүргийнхээ дагуу санхүү үйлчилгээний ажлыг зохих ёсоор явуулахад шаардлагатай асуудлаар удирдах байгууллагын шийдвэрийн төсөл, санал боловсруулж холбогдох байгууллагатай зөвшилцөж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, түүний Тамгын газарт тавих.

3.2. Нэмэгдэл төсвийг бүрдүүлэх, зардал хэмнэх зорилгоор газрын харъяа түр буюу байнга ажиллах нэгж зохион байгуулах, бүтцэд нь өөрчлөлт оруулах, татан буулгах асуудлаар Нийслэлийн Засаг даргад санал тавьж, шийдвэрлүүлэх.

3.3. Харъяа байгууллагуудын зохион байгуулалтын бүтцийг батлах, тэдгээрийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах асуудлыг зохих журмын дагуу нийслэлийн Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэх.

3.4. Харъяа байгууллагуудын удирдах албан тушаалтныг томилоход санал өгөх, тэдний ажлын талаар томилсон байгууллагад нь саналаа оруулах.

3.5. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан хүмүүсийг төр, засгийн болон Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шагналд уламжлах, газрын шагналаар шагнах.

3.6. Харъяа байгууллагуудын үйл ажиллагааны жил, хэтийн зорилт, төсвийн төслийг нэгтгэн боловсруулах, газрын батлагдсан төсвийг захиран зарцуулж, тайлагнах.

3.7. Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжоор олгогдсон бусад эрхийг эдлэх.